

**ДОТООД АУДИТЫН АЖПЫН БАРИМТ: АБ4000**

Аудит хийгдсэн байгууллага:

"ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ"

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ  
ДОТООД АУДИТЫН ХОРОО**

**- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -**

**2024 он**

**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000**

**АУДИТ ХИЙСЭН  
БАЙГУУЛЛАГА:**

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
САЙДЫН ДЭРГЭДЭХ “ДОТООД АУДИТЫН ХОРОО”**

**АУДИТ ХИЙГДСЭН  
БАЙГУУЛЛАГА:**

**“ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
ЯАМ”**

**АУДИТЫН ТӨРӨЛ:**

**ДОТООД АУДИТ**

**АУДИТЫН ХУГАЦАА:**

**2024.09.30-2024.10.04**

**Ажлын хэсгийн ахлагч:**

Х.Ган-Очир

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын дарга**

**Гишүүн:**

А.Гэрэлт-Од

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын, ахлах шинжээч**

Д.Мөнгөнсувд

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын, ахлах шинжээч**

Ц.Ууганбаяр

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын шинжээч**

**Нарийн бичгийн дарга:**

Б.Цолмон-Эрдэнэ

**Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын шинжээч**

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
  - 2.1 Аудитын зорилго
  - 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт
  - 2.3 Аудитын арга, аргачлал
3. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ
  - 3.1 Байгууллагын сайн туршлага
  - 3.2 Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн мэдээлэл
4. АУДИТЫН ҮР ДҮН
5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

## 1.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтооолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм, 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал", Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс баталсан холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам болон Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 136 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн" сэдэвт хүний нөөцийн аудитын удирдамжийн дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцкуулалтын яамны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

### 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилтэд дотоод аудитыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Яамны хүний нөөцийн бодлого
- Сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөр
- Үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, явц, үр дүнгийн тайлан
- Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдын хувийн хэрэг
- Бусад холбогдох мэдээлэл

### 2.3 Аудитын арга, аргачлал

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга болон Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Статистик, мэдээллийн сангийн хэлтсийн дарга нарт дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 05 дугаар хуралдаанаас зөвшөөрсөн" Хүний нөөцийн аудит хийх гарын авлагы"д дурдсан асуултуудад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн баримтыг нягтлан шалгасан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бүтэц орон тоо зэргээс олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглувалж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээ /ОУМПХ/
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Монгол Улсын Засгийн Газар, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас баталж гаргасан холбогдох эрх зүйн баримт бичгүүд
- Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай /2022 оны Б/110/

### 3. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

#### 3.1. Байгууллагын сайн туршлага

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам нь Төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлж, Төрийн захиргааны төв байгууллагуудыг манлайлан түүчээлж, Олон улсын чанарын менежментийн тогтолцоо "ISO 9001:2015" стандартыг нэвтрүүлсэн анхны яам болж, Олон улсын баталгаажуулалтын гэрчилгээг 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр гардан авсан сайн туршлагатай байна.

#### 3.2. Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн мэдээлэл

Засгийн газрын "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны зохион байгуулалтын бүтцийг:

1. Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар /Орон сууцжуулалтын хэлтэс, Статистик, мэдээллийн сангийн хэлтэстэй/;
2. Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар /Хот дахин төлөвлөлтийн хэлтэстэй/;
3. Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар /Барилгын материалын хэлтэстэй/;
4. Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар /Инженерийн дэд бүтцийн хэлтэстэй/;
5. Төрийн захиргааны удирдлагын газар /Хуулийн хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй/;
6. Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төсөл, хөтөлбөрийн хэлтэстэй/;
7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
8. Салбарын хяналтын газар /Инженерийн байгууламжийн хяналтын хэлтэстэй/ буюу 8 газар, 10 хэлтэстэйгээр орон тооны дээд хязгаарыг 99 байхаар тогтоосон.

Мөн Засгийн газрын 2024 оны 51 дүгээр тогтоолоор "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг шинэчлэн баталсан байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Б/10 дугаар "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" тушаалыг баталж, мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг Төрийн захиргааны удирдлагын газарт Сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтний 1 орон тоо, Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Статистик, мэдээллийн сангийн хэлтэст 4 орон тоо нийт 5 орон тоотойгоор баталсан байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан тушаалын судалгаа:

№	Албан тушаал	Албан тушаалын ангилаал, зэрэглэл	Овог нэр	Тухайн байгууллагад ажилласан жил	Тусгай шалгалт өгсөн эсэх	Зэрэг дэв
1	Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Статистик, мэдээллийн сангийн хэлтсийн дарга	Эрхэлсэн түшмэл, Т3-3	Нямсүрэнгийн Нарантуяа	19 жил	Өгсөн	Эрхэлсэн түшмэлийн дэтгөөр зэрэг
2	Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого,	Ахлах түшмэл, Т3-5	Энхбаатарын Ариунцэцэг	5 жил	Өгсөн	Ахлах түшмэлийн гутгаар зэрэг

## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ АБ4000

	зохицуулалтын газрын Статистик, мэдээллийн сангийн хэлтсийн Салбарын цахим бодлого, мэдээллийн нэгдсэн сан хариуцсан шинжээч		/хүүхэд асрах чөлөөтэй/-сул орон тоо			
3	Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Статистик, мэдээллийн сангийн хэлтсийн Программ хангамж, өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтэн	TY-7	Сул орон тоо		-	-
4	Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Статистик, мэдээллийн сангийн хэлтсийн Салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем хариуцсан мэргэжилтэн	TY-7	Цэлмэгийн Лхагвадорж	1 жил	-	-
5	Төрийн захиргааны удирдлагын газрын Сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл, ТЗ-6	Наранцэцгийн Цогт /Түр орлон/ /Сэлгэн ажиллаж байгаа албан хаагч П.Баасан/	1 сар	Өгсөн	-

## 4. АУДИТЫН ҮР ДҮН

<b>Илэрсэн асуудлын төрөл</b>	Дотоод аудит
<b>Илэрсэн Асуудал 1</b>	Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын талаар
<b>Асуудлын ангилаал</b>	Нелөө ихтэй
<b>Бодит байдал:</b>	
<p>1. Барилга, хот байгуулалтын яамны Сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт сэлгэн ажиллуулахаар томилсон байна. Төрийн албан хаагчийг өөр байгууллагад сэлгэн ажиллаж байхад яамны Салбар зөвлөл тухайн албан тушаалыг сул орон тоо гарсан гэж үзэж 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Статистик, мэдээллийн технологийн хэлтсийн Сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн /Дэс түшмэл ТЗ-6/ албан тушаалд тусгай шалгалтын зарыг байршуулж, тусгай шалгалтыг 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан байна.</p>	
<p>2. Тусгай шалгалтын шаардлагыг хангаж, тусгай шалгалтад Наранцэцэгийн Цогт тэнцэж, Салбар зөвлөлийн тогтоол 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр гарсан. Гэвч Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын "Албан тушаалд томилох тухай" 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар Сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн албан тушаалд Погнойн Баасанг сэлгэн ажиллаж байгаа албан хаагчаар томилсон байна.</p>	
<p>3. 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар Төрийн захирагааны удирдлагын Сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг Н.Цогтоор түр орлон гүйцэтгүүлэхээр томилсон байна.</p>	
<p>4. Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 186 дугаар тогтоолыг үндэслэн Барилга, хот байгуулалтын яам /Хуучин нэршил/-ны Төрийн нарийн бичгийн даргын "Албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах тухай" 2024 оны 05 дугаар сарын 28-ний өдрийн Б/95 дугаар тушаалаар баталсан байна.</p>	
<p>5. Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Статистик, мэдээллийн сангийн хэлтсийн Салбарын цахим бодлого, мэдээллийн нэгдсэн сан хариуцсан шинжээч Э.Ариунцэцэгийг хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд, Программ хангамж, өгөгдлийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалын сул орон тоо байна.</p>	
<b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b>	
<p>Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаар тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах ёстой.</p>	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b>	
<p>1. Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулж байхад албан тушаалын сул орон тоо гарсан гэж тусгай шалгалтыг зохион байгуулсан байна.</p>	
<p>2. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын "12.3. Нэр дэвшсэн албан хаагч, иргэнийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан Зөвлөл, Салбар зөвлөлийн тогтоолыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор томилно." гэж заасантай нийцэхгүй байна.</p>	

3. Төрийн жинхэнэ албаны нөөцөд байсан иргэн тусгай шалгалт өгсөн ч тухайн албан тушаалд түр томилогдож албан хаагчийн эрх зүйн байдал дордсон байна.
4. Сул орон тоог нөхөөгүй байна.
5. Албан тушаалын тодорхойлолт шинэчлэгдэн батлагдаагүй байна.

**Байгууллагад үзүүлэх нөлөө /ур дагавар/**

Яамны дэргэдэх Салбар зөвлөл хууль журмын дагуу ажиллаагүйгээс албан хаагчийн эрх зүйн байдал дорсон байна.

**Зөвлөмж:**

1. Сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд хууль журмын дагуу томилгоог хийх.
2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" тогтоолын дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах ажлыг шуурхай зохион байгуулах;
3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөл хууль журмын дагуу сул орон тоог нөхөх.

<b>Илэрсэн асуудлын төрөл</b>	Дотоод аудит
<b>Илэрсэн Асуудал 2</b>	Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн мэргэжлийн сургалт, хөгжүүлэлт, нийгмийн баталгааны талаар
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө багатай

**Бодит байдал:**

1. Харилцаа холбооны зохицуулах хорооноос Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдаас 2019-2024 оны хооронд Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалт, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт болон чиглүүлэх богино хугацааны сургалтад тус тус хамрагдсан байна. 2024 онд Харилцаа холбооны зохицуулах хорооноос зохион байгуулсан "Сүлжээ ба интернэтийн замчлалын үндэс" сэдэвт сургалт зохион байгуулагдаж албан хаагч сургалтын зардлыг өөрөөсөө гарган сургалтад хамрагдсан байна.
2. Барилга, хот байгуулалтын сайдын "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 71 дүгээр тушаалаар албан хаагчдын зэрэг дэвийг олгосон байна.

**Байх ёстой шаардлага /шалгуур/:**

Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогод төрийн албаны мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ыг өдөр тутмын үйл ажиллагаандaa мердлөг болгон ажиллах ёстай.

**Асуудлын үндсэн шалтгаан:**

Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчид тасралтгүй хөгжих шаардлагатай байдаг. Зарим төлбөртэй сургалтын төлбөрийг албан хаагчид өөрөөсөө гаргаж суралцсан ба систем хөгжүүлэх мэргэжлийн сургалт авах шаардлагатай байдаг байна. "Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасан төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин болон мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3-т заасан тусгай шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгоно" гэж заасан. 2024 онд албан хаагчдад зэрэг дэв олгогдоогүй байна.

**Байгууллагад үзүүлэх нөлөө /ур дагавар/:**

Мэргэжлийн боловсон хүчин хомсдох, төрийн албан хаагчдын зарим нийгмийн баталгаа хангагдахгүй байх.

**Зөвлөмж:**

1. Мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдын мэргэжлээр нь чадавхжуулах сургалтад хамруулах;
2. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг хугацаанд нь олгож хэвших.

**6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Дотоод аудитаар танай байгууллагад “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
“Сайжруулах шаардлагатай”	Засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79% нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.

**ТАНИЛЦСАН:**

Төрийн нарийн бичгийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч 

C.Төмөрхүү

**ТАЙЛАН ХЯНАСАН:**

ХШҮДАГ-ЫН ДАРГА БӨГӨӨД  
Дотоод аудитын хорооны гишүүн



Х.Ган-Очир

**ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:**

Дотоод аудитын хорооны  
нарийн бичгийн дарга



Б.Цолмон-Эрдэнэ